



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Тэрэлж Сүйх ХХК-ний “Тэрэлж” зочид буудлын 16/067, Цахиур төмөр сервис ХХК-ний “Роял” зочид буудлын 16/098, Эс Ди Эн ХХК-ний “Отгонтэнгэр” зочид буудлын 13/148, Хонгконглүюу ХХК-ний “Хонгконг” зочид буудлын 16/061, Иргэн Я.Цэнджавын “Анир” дэн буудлын 13/137, Омега ХХК-ний “Номун” амралтын газрын 16/053 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

1150500305

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны ᠙ сарын ᠒᠒
өдрийн ᠙᠘ дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.10.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эс Ди Эн ХХК	2711109	Отгонтэнгэр	БНД-ийн 3-р хороо 50-р байр-1
2	Цахиур төмөр сервис ХХК	5819105	Роял	БГД-ийн 5-р хороо Энхтайваны өргөн чөлөө-32
3	Тэрэлж Сүйх ХХК	5403715	Тэрэлж	НД-ийн 6-р хороо Жо Вангийн адагт
4	Хонгконглүүю ХХК	5148391	Хонгконглүүю	СХД-ийн 13-р хороо Москва-49
5	Түүскай ХХК	5260035	Майами	СБД-ийн 4-р хороо Энхтайваны гудамж Лаки төвийн байр

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 10 сарын 11
өдрийн А/30 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2017.10.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Я.Цэнджав	Ию73092803	Анир	СХД-ийн 13-р хороо 8/4
2	Ихбаян нуур ХХК	2069385	Өнөр төв	СХД-ийн 13-р хороо Өнөр төвийн байр

---ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 10 сарын 11
өдрийн 6180 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.10.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Лүүк Монголиа ХХК	2626772	Тэрэлж лодж	НД-ийн 6-р хороо Онгоцтын ам
2	Самбарай ХХК		Төгөл	СХД-ийн 25-р хороо
3	Омега ХХК	2062801	Номун	СБД-ийн 20-р хороо Сэлбэ зусланд
4	Араг бургас ХХК	2008955	Бүрэг эрэг	БНД-ийн 4-р хороо
5	Аянчин Фоор Сийзонз Лодж ХХК	2872595	Аянчин	НД-ийн 6-р хороо Эрээний адаг
6	Жамо гранд трэйвел ХХК	5861454	Дрийм тэрэлж Лодж	НД-ийн 6-р хороо Баргын өвөлжөө

--ooOoo--